



ХАН-УУЛ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 07 сарын 29 өдөр

Дугаар 5/25

Улаанбаатар хот

Ц.Ган-Эрдэнийг албан тушаалаас
чөлөөлөх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хөдөлмөрийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.1.9, 79 дүгээр зүйлийн 79.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хан-Уул дүүргийн Зам засвар, арчлалт орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын захирал Цэнээгийн Ган-Эрдэнийн гаргасан хүсэлтийг үндэслэн түүнийг 2024 оны 7 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

2.Ц.Ган-Эрдэнийн ажил хүлээлцэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	З.Буянт	Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга
Гишүүд:	Б.Янжмаа	Нягтлан бодогч
	Б.Мархагүл	Архивч
Нарийн бичиг:	Б.Саранцацрал	Хүний нөөц, хөрөнгө, орлогын мэдүүлэг хариуцсан мэргэжилтэн

3.Ц.Ган-Эрдэнийн ажлыг 2024 оны 7 дугаар сарын 31-ний өдөрт багтаан хүлээлцэхийг ажлын хэсэг (З.Буянт)-т, холбогдох бусад тооцоог хийж дуусгахыг Засаг даргын Тамгын газар (С.Энхбаяр)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ЦЭРЭН

1726011090